

## ГЛОБАЛЧЛАЛЫН НӨХЦӨЛ ДЭХ ЯПОНЫ ЭДИЙН ЗАСАГ

*Ц. Баатар\**

Эдийн засгийн глобалчлалын нөхцөлд Япон орон Азид цаашлаад дэлхийн эдийн засагт ямар үүрэг рольтой байх вэ? Дотооддоо глобалчлалтай уялдуулан зохицуулж эдийн засаг, нийгмийн ямар ямар бүтцийн шинж чанартай өөрчлөлт, шинэчлэлт хийх талаар Японы Эдийн Засгийн Зөвлөлийн дэргэдэх Глобалчлалын Хороо өнгөрсөн зууны эцэст буюу 1999 оны зургаадугаар сард тусгай судалгаа хийж 6 хэсгээс бүрдэл болсон томоохон илтгэл бэлтгэж засгийн газартаа оруулсан байдаг. Илтгэлд дурдснаар глобалчлал Японы эдийн засагт ихээхэн эерэг нөлөө үзүүлж буй аж. Тухайлбал, Японы корпорациуд, бизнесийн хүрээнийхэн байрлалаа чөлөөтэй сонгон сэлгэх өргөн боломж олгожээ. Японы бизнес эрхлэгчид орон нутгаасаа гарч Ази болон Хойт Америкийн илүү тааламжтай орчныг сонгон байр сууриа тэлэн өргөтгөж, ашиг орлогоо нэмэгдүүлж чадсан байна.

Глобалчлалын ачаар Японы бараа бүтээгдэхүүний эрэлт, нийлүүлтийн шатанд ахиц гарч эргэлт түргэсч, өрсөлдөөнийг урамшуулж компаниудын ашгийг нэмэгдүүлж, бүтээгдэхүүний үнэ ханшийг бууруулах таатай орчныг буй болгож байна гэж уг илтгэлд өгүүлжээ.

Глобалчлал Японы аж үйлдвэрт оновчтой бүтэц бий болгох, одоогийн бүтцийг хурдан өөрчлөх, мэдээжийн хэрэг ажил эрхлэлтийг нэмэгдүүлэхэд ч нааштай нөлөө үзүүлж буй аж.

Глобалчлалын үндсэн хүчин зүйлийн нэг нь мэдээллийн технологийн түргэн хурдацтай хөгжил болж байгааг дурдаад энэ нь Японд төдийгүй дэлхий дахины ач холбогдолтой түүхэн үйл явц болохыг илтгэлд дурьджээ.

Дээрхи илтгэлд өгүүлснээр Япон улс 2010 оны орчимд ч дэлхийн тэргүүлэх эдийн засагтай орон хэвээр байж дэлхий нийтийн ач холбогдолтой үйл явдлыг шийдвэрлэхэд үзүүлж ирсэн

\* Ц.Баатар - ШУА-ийн Олон Улс Судлалын Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

тусламж дэмжлэг өнөөгийн байр суурь, үүрэг роль өсөх хандлагатай гэсэн дүгнэлт хийсэн байна.

Япон улс XXI зууны босгон дээр дэлхийд эдийн засгийн зонхилогч гүрний байр сууриа хэвээр хадгалах үүднээс эдийн засгийн бодлогын шинэчлэл хийж эхэллээ. Японы Засгийн газар энэ талаар хоёр бодлого баримталж байна. Нэг нь эдийн засгийн амьдралд төрийн оролцоог нэмэгдүүлж, хямралын эсрэг удирдамжийг хэрэгжүүлэх. Нөгөө нь либериал шинэтгэл хийх тухайлбал улсын хэвшлийн аж ахуйн нэгжийг хувьчилж, төсвийн системийг шинэтгэх, монополийн эсрэг хууль тогтоомжийг хянан үзэх зэрэгт чиглэж байна.

Шинэ зууны эхээр эдийн засгийн өсөлтийн хурдыг хоёр хувь болгохыг зорьж байна. Гэхдээ энэ зорилтыг биелүүлэхэд хүн ам зүйн тааламжгүй хэтийн төлөв, эрэлт хэрэгцээний болон орон сууцны барилга байгуулалтын явц, үйлдвэрийн газруудын үндсэн хөрөнгийн шинэчлэлт зэрэг багагүй бэрхшээл тулгарч байна.

2010-2015 оны орчимд Японы эдийн засгийн өсөлт тогтворжих аж. Гэвч энэ улсын хүн амд хөгшрөх хандлага давамгайлж байгаа нь хөдөлмөрийн нөөц ихээхэн хорогдоно гэсэн үг. Иймд цалин хөлсний төвшин бусад орнуудынхаас илүү хурдан нэмэгдэж, хөдөлмөрийн хөлс 10-15 дахин хямд байдаг улсуудын бүтээгдэхүүнтэй Япон улс өрсөлдөхөд хүрнэ. Технологийн талаар манлайллаа хадгалахын тулд “арилжаа наймааны шинжтэй” аж үйлдвэрийн технологи давуутай үйлдвэрлэдэг зуршлаа орхиж, суурь судалгааны түвшинг дээшлүүлж, үзэл санаа, технологийн олон улсын солилцоог өргөжүүлэх зорилт дэвшүүлээ.

Олон улсын өрсөлдөөний түрэлт нь өрсөлдөх чадвараа алдаж буй салбарыг зах зээлээс шахан гаргах болно. Япон улс Ази-Номхон далайн бүс нутгийн удирдагчийн хувьд дэлхийн эдийн засагт байр сууриа бэхжүүлж үндэсний валютаараа Азид тооцоо хийх, нөөцлөх гол валют болгож, Америкийн долларыг орлодог болгохыг эрмэлзэх аж. Энэ нь тус улсын аль ч компани ажилчдаа насаар нь хөлслөх, ахимаг насны албан хаагчдадаа цалин хөлс илүү төлөх журам нь зардлыг бууруулах шаардлагатай нийцэхгүй байгаа бөгөөд нийгмийн тогтвортой байдлын баталгаа болох үүргээ алдаж байна. Хуучны энэ практикийн оронд чөлөөтэй хөлслөх, мэргэжил болон хөдөлмөрийн үр дүнгээр нь цалинжуулах журамд шилжиж байгаа бөгөөд ажиллах хүчний зах зээлийг цоо

шинээр үүсгэн бий болгох замд эргэлт буцалтгүй орлоо. Дотоодын эдийн засгийн шинэтгэлийн хүрээнд ажлын байр шинээр бий болгох, ажилгүйдлийг багасгах нэг гол хөшүүрэг бол жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг ч хөхүүлэн дэмжих чиглэл баримтлах аж. Тийм учраас Японы жижиг, дунд үйлдвэрийн онцлогийг энд тухайлан авч үзэх нь зүйтэй болов уу гэж үзлээ. Учир нь Монголд ч гэсэн ажлын байр бий болгох бодлогын хүрээнд энэ улсаас санаа оноо авах зүйл байгаа нь мэдээж.

Японд нийт үйлдвэрийн 99 хувийг жижиг, дунд үйлдвэрүүд эзэлж, тэд нэмэгдсэн өртгийн 55 хувийг бүтээж, аж үйлдвэрийн салбарт ажиллагсдын 70 хувь нь жижиг, дунд үйлдвэрүүдэд ажиллаж байна. Үйлчилгээний салбарт энэ хувиуд өндөр байдаг. Тухайлбал үйлчилгээний салбарт ажиллагсдын тоонд жижиг, дунд үйлдвэрүүдийн эзлэх хувиас нэмэгдсэн өртөгт эзлэх хувь нь 15-аар илүү байдаг. Үйлчилгээний салбар нийт ажиллах хүчний 70 хувийг ажиллуулж, нийт бүтээгдэхүүний 55 хувийг үйлдвэрлэдэг. Энэ нь жижиг, дунд үйлдвэрүүдэд хөдөлмөрийн бүтээмж том үйлдвэрүүдийнхээс бага байдгийг харуулж байна. Ийм сул талтай ч гэсэн Японд яагаад жижиг, дунд үйлдвэрүүд эрчимтэй хөгжих болсон бэ? Хөдөлмөрийн бүтээмжийг 2 үндсэн хэсэгт хувааж болно.

*Хөдөлмөрийн бүтээмж=Капитал ба хөдөлмөрийн харьцаа  
\*Хөрөнгө оруулалтын үр ашиг*

$$(Y/L)=(A/L)*(Y/A)$$

*Хөдөлмөрийн бүтээмж=Нэмэгдсэн өртөг (Y)/Ажиллагсдын тоо (L)  
Капитал ба хөдөлмөрийн харьцаа = Капитал буюу үл хөдлөх  
хөрөнгө (A)/Ажиллагсдын тоо (L)*

*Хөрөнгө оруулалтын үр ашиг = Нэмэгдсэн өртөг (Y)/Капитал буюу үл  
хөдлөх хөрөнгө (A)*

Капитал ба ажиллагсдын тооны харьцаа нь нэг ажиллагчид ногдох үл хөдлөх хөрөнгийн хэмжээг харуулдаг. Хөрөнгө оруулалтын үр ашгийн харьцаа нь нэгж капитал ямар хэмжээний бүтээгдэхүүнийг бий болгодгийг илэрхийлсэн индекс юм. Том үйлдвэрүүдийн хувьд тэд их хэмжээний хөрөнгө оруулалт хийдэг ба капитал хөдөлмөрийн харьцаа нь жижиг үйлдвэрүүдтэй харьцуулахад мэдэгдэхүйц өндөр байдаг. Үүгээр янз бүрийн хэмжээний үйлдвэрүүд нь хөдөлмөрийн

бүтээмжээрээ ялгаатай байх гол шалтгааныг тайлбарлаж болно. Нөгөө талаас жижиг, дунд үйлдвэрүүдийн капиталын үр ашиг том үйлдвэрүүдтэй харьцуулахад өндөр байдаг. Жижиг үйлдвэрүүдийн үл хөдлөх хөрөнгийн ашиглалтын үр ашиг ч өндөр байдаг. Японд жижиг, дунд үйлдвэрүүдийн дундаж хөдөлмөрийн бүтээмж нь нэг ажиллагчдад 45,000 ам доллар байдаг бол том хэмжээний үйлдвэрүүдийн хувьд 90,000 ам доллар байдаг. Жижиг, дунд үйлдвэрүүдийн капитал хөдөлмөрийн харьцаа дунджаар 67,000 ам доллар байхад том үйлдвэрүүдийн хувьд 205,000 ам доллар буюу 3 дахин их байдаг. Харин жижиг, дунд үйлдвэрүүдийн хөрөнгө оруулалтын үр ашгийн харьцаа нь том үйлдвэрүүдийнхээс 50 хувиар илүү байдаг. Тухайлбал дунджаар энэ харьцаа жижиг, дунд үйлдвэрүүдийн 0,67 байхад том үйлдвэрүүдэд 0,44 байсан байна. Борлуулалтын хэмжээ өссөн тохиолдолд капитал хөдөлмөрийн харьцаа өндөр байх нь ашгийн хэмжээг нэмэгдүүлдэг. Гэвч борлуулалтын хэмжээ буурах тохиолдолд тогтмол зардал нь өндөр байдгаас болж тухайн компанийн ашгийн түвшин маш хурдан буурдаг. Үүнээс шалтгаалан компанийн санхүүгийн удирдлагад тогтворгүй байдал үүсдэг. Иймээс жижиг, дунд үйлдвэрүүдийн капитал хөдөлмөрийн харьцаа бага байх нь удаан хугацаанд тогтвортой ашгийн түвшинг хадгалах гэсэн эдийн засгийн утгыг агуулна. Хөрөнгө оруулалтын үр ашгийн хувьд гэвэл үйлдвэрийн хэмжээнээс хамаарахгүйгээр энэхүү харьцаа өндөр байх тусам сайн байдаг.

Жижиг, дунд үйлдвэрүүдийн хувьд хөрөнгө оруулалтын үр ашгийн харьцаа өндөр байгаа нь ажилчдыг сургалтанд хамруулах, техникийн шинэчлэл хийх, хомсдолтой байгаа нөөцийг зөв хуваарилах гэх мэт үйл ажиллагааны үр дүн юм. Японы том хэмжээний Сони корпораци болон Хонда компаниуд 50 жилийн өмнө өөрийн үйл ажиллагаагаа жижиг хэмжээний бизнесээр эхлэж байсан ба хүний нөөцийг хөгжүүлэхэд хийсэн хөрөнгө оруулалт, техник технологийн шинэчлэл, байгаа нөөцөө үр ашигтай хуваарилах зэрэг асуудалд байнга анхаарч ирсний үр дүнд өнөөдрийн амжилтад хүрээд байна. Тийм ч учраас Япон улс цаашид ч жижиг дунд үйлдвэрлэлийг зохистой хэмжээнд хөгжүүлэх чиглэл баримталж буй нь энэ болов уу. Гэхдээ энэ салбарт ч шинэчлэл, өрчлөлт зайлшгүй шаардлагатай гэж үзэж байгаа.Түүний зэрэгцээ электрон болон мэдээллийн технологи хүчтэй хөгжиж буйн улмаас ажлын байр хорогдож

байгааг харгалзан төрөөс жижиг дунд үйлдвэрлэл эрхлэхийг хөхүүлэн дэмжиж, бүтээгдэхүүнийг нь зах зээлд гарган борлуулахад туслалцаа үзүүлэх зэргээр ажлын шинэ байр бий болгох чиглэлээр ажилгүйдлийг аль болох нэмэгдүүлэхгүй, нийгмийг бухимдалд оруулахгүй байх чиглэлээр оновчтой хувилбарыг хэрэглэн уялдуулан зохицуулах чиг бодлого баримталж эхэллээ. Орлого болон хуримтлуулсан хөрөнгийн хэмжээгээр нь япон айл өрхийн ялгаврыг багасгаж, том хотуудад орон сууцны асуудал хурц байгааг шийдвэрлэн нийгмийн хангамжийн системд дорвитой шинэтгэл хийхээр төлөвлөжээ.

Амьдралын төвшин. 1998 онд Японд дотоодын нийт бүтээгдэхүүнийг хүн ам тутамд оногдуулж бодвол 29925 ам. доллар болсон нь Швейцарь, АНУ-ын дараа буюу дэлхийд гуравт орж байгаа юм.. Энэ тоо нь дундаж япон хүний амьдрал харьцангуй дээд төвшинд байгааг илтгэж байна. Гэхдээ энэ нь ямар ч мөчид ханш нь буурч мэдэх доллартай харьцуулах иений ханш таатай байгаад үндэслэсэн аж. Учир иймээс дээр дурдсан тоо баримт юмны жинхэнэ байдлыг бүрэн тусгаж чадахгүй. Бусад хүчин зүйлд нарийвчилсан дүн шинжилгээ хийх хэрэгтэй юм.

Японы эдийн засгийн төлөвлөлтийн агентлаг ард түмнийхээ аж амьдралын төвшинг бусад орнуудынхтай харьцуулж, өрхийн зарлагын бүтцэд дүн шинжилгээ хийдэг аж. 1998 онд явуулсан сүүлчийн судалгаагаар Токиод юмны үнэ Нью-Йоркийнхтай харьцуулахад 52 хувиар илүү байлаа. Ер нь Японд, ялангуяа том хотуудад нь газрын үнэ өөр ямар ч орныхтой зүйрлэхээргүй өндөр. Түрээсийн хөлс дунд зэргийн амьжиргаатай иргэний мөрөн дээр хүнд дарамт болдог гэнэ.

Иймэрхүү зохисгүй байдлыг залруулж, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах нь Японы Засгийн газрын XXI зууны гарааны нэн чухал зорилт болж байна.

#### ЯПОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙН ЧИГ ХАНДЛАГА

Японд 1997 онд дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хурдац 0,5 % болж, харин 80-аад онд өсөлтийн дундаж хурдац 4%-д хүрч байсан юм. Энэ байдлын шалтгаан нь Зүүн өмнөд Азийн орнуудын санхүү-эдийн засгийн хямрал төдийгүй, Японы өөрийнх нь санхүүгийн тогтолцооны бүтцийн бэрхшээлтэй асуудал,

тухайлбал өрийг их хэмжээгээр буцааж төлсөн явдал байв. Үүнээс гадна, улсын хөрөнгө оруулалтыг бүхэлд нь хатуу багасгасан явдал, төслийн алдагдлын харьцаа нь эдийн засгийн үлбэгэр конъюнктурын шалтгаан бас болсон юм.

Бүхэлдээ японы үйлдвэрлэгчид, ялангуяа томхон үйлдвэрийн газрууд экспортоо нэмэгдүүлсний үндсэн дээр муугүй үр дүнд хүрч байна. Гэвч жижиг болон дунд зэргийн үйлдвэрийн газрууд, түүнчилэн эдийн засгийн аж үйлдвэрийн биш секторуудын ажил төрөл нэлээд муу байна. Хэрэглээний үнэ тогтвортой байгаа ч (1997 онд энэ үнийн өсөлт ердөө 0,8% байв), японы жишигээр ажилгүйдлийн түвшин харьцангуй өндөр хэвээр байгаа нь орлогод сөргөөр нөлөөлж, хэрэглээний эрэлтийг барьж байна.

1997 оны туршид Японы гадаад худалдаа нэн эрчимтэй өссөн нь олон улсын томоохон зээлдүүлэгч болох тус орны байр суурийг халгалан барьж чадсан аж. Иенийн доогуур ханш нь экспортын хувь өндөр байхад тус дөхөм болжээ. Японы иенийн ханшийг бууруулахгүй байх нөхцөлд экспорт өсөх хандлага хэвээр байх болов уу.

1997 оны арванхоёрдугаар сард засгийн газар экспортод түлхэц өгөх багц арга хэмжээг зарласан бөгөөд үүнд тус орны банкны суларч ганхсан системийг тогтворжуулахын тулд 10 триллион иенийн (77,8 тэрбум ам. доллар) засгийн газрын тусгай облигац гаргах замаар орлогын татварыг 2 триллион иенээр (15,6 тэрбум доллар) багасгах арга хэмжээ орсон юм. Банкнуудын зүгээс зээл өгөх хэмжээ багассан нөхцөлд дунд зэргийн пүүсүүдийг дэмжих зорилгоор засгийн газар 12 триллион иенийн (91,6 тэрбум ам доллар) бага хүүтэй зээл өгөхөөр шийдвэрлэжээ.

Японд дэлхийн хоёрдугаар дайнаас хойшхи эдийн засгийн хамгийн хүнд хямрал гарч болох юм гэж 1999 оны тавдугаар сарын 18-нд Америкийн “Уолл-стрит” сонинд бичиж байжээ. Японы уналт дэлхийн бусад хэсгийн эдийн засгийн байдалд шууд таагүй нөлөөлсөн бөгөөд учир нь Япон дэлхийн эдийн засгийн томоохон гүрнүүдийн нэг бөгөөд тойруугаар авч үзэхэд тус улсын байдал нь Азийн худалдааны түншүүдийн эдийн засгийн өсөлтийг хязгаарлаж байгаа юм. Ийм цөхөрсөн байдал нь улсын асар их өр болон санхүүжүүлэх мөнгө байхгүй болсон тэтгэврийн асар их үүрэг гэсэн хоёр үндсэн шалтгаантай юм. ОУВС-гийн тоо баримтаас үзвэл одоо Японы улсын өр дотоодын нийт бүтээгдэхүүний 130% болж байна.

Үүний хамт, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын тооцооноос үзвэл Японы тэтгэврийн нийт үүрэг одоо дотоодын нийт бүтээгдэхүүний 107%-иас давж байна. Японы эдийн засаг цар хэмжээгээрээ АНУ юмуу Европын бүсийн эдийн засгийн тэн хагас нь л болж байгаа ч Японы нийт өр дэлхийд улсын хамгийн том өр болж байна.

Ажлын шинэ байр гаргахад чиглэсэн эдийн засгийн дахин гүн зохицуулалт хийх нь Японд аль эрт туслаж чадах байсан ч, улс төрийн зогсонги систем ингэх чадваргүй юм. Японы төв банк эдийн засгийг намгаас татаж гаргах зорилгоор хувьцаа, доллар худалдан авахын тулд улам их иен хэвлэснээр, бас оновчтой үүрэг гүйцэтгэж чадах юм. Гэвч одоо тус банк 30-аад оны хямралын үед АНУ-ын холбооны нөөцийн системийн хийсэн шиг тийм гайхамшигтай зүйл гарахыг хүлээнэж байна. Корпорацуудын байдал сайнгүй байгаа бөгөөд тэдгээрийн бүтцийн өөрчлөлт ихэнхдээ хамгаалалтын шинжтэй байгаагийн сацуу ажлын байрыг нэмэгдүүлэх биш харин багасгахад чиглэж байна.

“Хэрвээ өрийн сүлжээний зайлшгүй динамикийг нугалан дарахгүй бол, энэ бүхэн яаж дуусах вэ? Санхүүгийн сүйрлээр дуусч болох юм, ингэхдээ Японы эдийн засаг, санхүүгийн цар хүрээ асар их учир Мексик юмуу Бразилд тусласан шигээр ОУВС, АНУ –ын аль аль нь Японд санхүүгийн тусламж зохион байгууламж чадахгүй” гэж “Уолл-стрит жорнэл” сонинд бичжээ.

Япон санхүүгийн либералчлалаас татгалзан энэ хямралыг шийдвэрлэхэд чиглэсэн бодлого баримтлавал жинхэнэ аюул болно. Энэ тохиолдолд Азийн олон орон Японы зохион байгуулсан Азийн санхүүгийн бүсэд орохсон билээ. Энэ бүсэд санхүүг хатуу зохицуулж, капиталын экспортод хяналт тавих болно. Тийнхүү, японы хямрал нь Азийн бусад орныг Японтой нэгдэж, эдийн засгийн цагийн зүүг буцаахад хүргэж болох юм.

“Эрүүл нахиа нурунгийн завсраар нэгэнт цухуйн гарч байгаа нь эргэлзээгүй бөгөөд Азийн хямрал нэгэнт түүх болж үлдлээ” хэмээн олон хөрөнгө оруулагч үзэж байна гэж америкийн долоо хоног тутмын “Бизнес уик” сэтгүүл 1999 оны тавдугаар сарын 3-ны өдрийн дугаартаа Азийн эдийн засгийн байдлын тухай ОУВС-гийн дүгнэлтийг тайлбарлан бичжээ. Энэ оны хоёрдугаар сарын дундаас Индонез, Таиланд, Гонконгийн фондын биржүүд дэлхийн шилдэг үзүүлэлтүүдийг хангадаг биржүүдийн тоонд орж

байна. Гэвч Азийн эдийн засгийн өсөлт хэвээр байх болов уу гэдэгт хамаг учир оршиж байгаа бөгөөд энэ асуудал бас шийдэгдээгүй байна. 1998 онд Өмнөд Солонгос, Малайзид маш хүчтэй уналт болсоны дараа 1999 онд эдгээр оронд өсөлт 1-3% байх болно гэж хувиараа эдийн засаг судлагчид таамаглаж байна. Гэвч Азийн орнуудад төлбөрийн балансын алдагдалтай байдлыг сайжруулах нь улсын төсвийн их зарлагатай түүний дотор банкуудыг аврах зарлагатай, түүнчлэн гадаадын санхүүгийн байгууллагуудаас авах 100 тэрбум гаруй долларын яаралтай зээлтэй үлэмж холбоотой юм.

Азийн орнуудын эдийн засгийн бодит байдал бүхэлдээ бас ч тогтворгүй хэвээр байна. Ажилгүйдэл хэрэглэгчдийн зарлага үргэлжлэн өсч харин арилжааны банкууд хувийн секторт бас зээл олгохгүй хэвээр байна. Төлбөрийн балансыг бэхжүүлэх гэвэл экспортыг нэмэгдүүлэхээсээ импортыг багасгах хэрэгтэй болов уу. Өмнөд Солонгос, Хятад, Индонез зэрэг орнуудад экспорт бас л буурч байна. Төлөвшиж буй зах зээлтэй Азийн орнуудын гадаад өр бага зэрэг л багассан бөгөөд “Дойче банк”-ны мэдээгээр, 1999-2000 онд эдгээр орон зээл түүний хүүг төлөхөд 227 тэрбум доллар зарцуулах ёстой болно.

Бүс нутгийн байдалд бас ноцтой эрсдэл гарах аюул байсаар байна. Их ядуурал, омог аймгийн хямралдаанд орсон Индонез улс төрийн хувьд дарьтай торх хэвээр байна. Азийн эдийн засгийн хамгийн томхон хоёр гүрэн болох Япон, Хятад одоо нийт бүс нутгийн эдийн засгийн өсөлтийг тэргүүлж чадахгүй байна.

Ази тив хямралаас өмнө байсныг бодвол эдийн засгийн хувьд хавьгүй эрч хүч султайгаар одоогийн хямралаас гарна гэж долоо хоног тутмын сэтгүүлд бичжээ. Хэрвээ өмнөх хэдэн арван жилд төлөвшиж буй зах зээлтэй азийн орнуудын эдийн засгийн өсөлтийн хурдац жилд 7% байсан бол одоо ийм хурдац буцаж орох боломжгүй бөгөөд ойрын нэлээд хэдэн жилийн туршид өсөлт жилийн 1-2%-ийн түвшинд байх аж. Японы эдийн засаг найтааж эхэлбэл Азийн, Дэлхийн эдийн засаг ханиалгаж эхэлдэг гэдэг нь дээрхи судалгаанаас тодорхой харагдаж буй биз ээ. Азийн болон бүс нутгийн, дотоодын үй түмэн зохисгүй бэрхшээлтэй байдлыг даван туулж, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах нь Японы Засгийн газрын XXI зууны гарааны нэн чухал зорилт болж байна.



## АШИГЛАСАН ЭХ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН:

1. "World Development indicators 2001" World Bank Publication
2. Working with Peetrs for Financial Reforms in East Asia,Foundation for Community-Building in the Asia-Pacific,Inc.1999
3. The 3th United Nations Conference on the Least Developed Countries

*<http://www.mofa.go.jp>*

4. Economic Council Report of the Globalization Committee June 1999
5. Toward an Environmental Strategy for Asia / World Bank Discussion Papers/
6. World Economic and Social Survey 1999, Trends and Policies in the World Economy /Financial Development in the Globalizing World/, United Nations, New York 1999
7. "Өдрийн сонин" 2002.01.07